



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/123

Хэрлэн сум

Форум арга хэмжээнд төлөөлөгчдийг
оролцуулж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Бүгд Найрамдах Солонгос Улсад 2024 оны 03 дугаар сарын 16-аас 2024 оны 03 дугаар сарын 24-ны хооронд зохион байгуулагдах “Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, ашиглах форум”-д төлөөлөгчдийг оролцуулж, зардалд 3,368,000 (гурван сая гурван зуун жаран найман мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын ...-ны
... дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Нэгж үнэ		Нийт үнэ /төгрөг/
		Хүн	Зам/хоног	
1	Томиллолт /БНСУ/	5	1 хоног*673,600	3,368,000
	Дүн /төгрөг			3,368,000